Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсвийн 46,541,639.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 698,124.6 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэх үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт буурсан тул материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлаар тогтоосон.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт, төлөвлөлтийн үед сонгосон суурь үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй тул гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

“П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг”-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,427,914.8 мянган төгрөгөөр буюу 46.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	14,461.5	14,461.5
Авлага	442,107.5	3,815,999.1	3,373,891.7
Урьдчилж гарсан тооцоо	-	11,880.3	11,880.3
Бараа материал	3,688,460.6	6,272,349.5	2,583,888.8
Үндсэн хөрөнгө	39,339,632.0	53,783,424.5	14,443,792.5
Нийт хөрөнгө	43,470,200.1	63,898,115.0	20,427,914.8
Өр төлбөр	-	6,191,948.0	6,191,948.0
Засгийн газрын оруулсан капитал	17,104,644.4	17,104,644.4	-
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,061,553.4	21,061,553.4	-
Хуримтлагдсан үр дүн	5,304,002.3	19,539,969.2	14,235,966.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	43,470,200.1	63,898,115.0	20,427,914.8

Дараах дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 3,373,891.7 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДЕГ-аас авах санхүүжилт 3,815,313.1 мянган төгрөг болон хил гааль хаасантай холбоотой аж ахуйн нэгж, байгууллагын бараа материалын үлдэгдэл 686.0 мянган төгрөгтэй холбоотой;

Бараа материалын дансны үлдэгдэл 2,583,888.8 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотой хандив тусламж, эм, эмнэлэгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн бэлдмэл, хангамжийн материал зэргийг нөөц бүрдүүлсэн;

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 14,443,792.5 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар хийгдсэн барилгын засвар, хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгө, бусад худалдан авалттай холбоотой;

Өр төлбөр дансны үлдэгдэл 6,191,948.0 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДЕГ-аас санхүүжилт ороогүйгээс шалтгаалан эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн 6,058,722.2 мянган төгрөг болон бусад бараа, хангамжийн зүйлс, үйлчилгээнд 123,225.7 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүйтэй холбоотой байна;

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үндсэн үйл ажиллагааны орлого	6,902,800.9	5,226,883.7	(1,675,917.25)
Туслах үйл ажиллагааны орлого	169,257.6	1,311,123.2	1,141,865.59
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,087,509.9	23,189,085.8	18,101,575.89
Түрээсийн орлого	71,362.0	58,445.0	(12,917.02)
Тусламжийн орлого	91,610.3	-	(91,610.33)

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,497,595.6	-	(9,497,595.60)
Төсвийн захирагчдаас	-	2,000,000.0	2,000,000.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,921,842.3	39,797,177.3	12,875,335.01
Үйл ажиллагааны орлогын дүн	48,741,978.7	71,582,715.0	22,840,736.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,514,884.4	15,675,983.7	3,161,099.33
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,616,574.0	2,086,723.8	470,149.81
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	861,093.5	1,038,355.2	177,261.75
Хангамж, бараа материалын зардал	547,724.3	746,767.1	199,042.75
Нормативт зардал	25,162,405.8	28,814,518.0	3,652,112.10
Эд хогшил, урсгал засварын зардал	991,115.2	1,029,062.6	37,947.43
Томилолт, зочны зардал	18,346.5	23,165.5	4,819.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	119,851.1	112,228.9	(7,622.12)
Бараа, ажил үйлчилгээний бусад зардал	4,311,210.6	5,891,955.1	1,580,744.47
Бусад урсгал шилжүүлэг	398,434.1	1,143,055.6	744,621.43
Үйл ажиллагааны зардлын дүн	46,541,639.6	56,561,815.6	10,020,175.9

“П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг”-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 22,840,736.3 мянган төгрөг буюу 46.8 хувиар өссөн байна. Үүнд:

1. ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийг оношноос хамааруулан гүйцэтгэлд суурилан Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн.
2. Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Эрүүл мэндийн яамны хандив, тусламжаас нэмэгдсэн.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн үйл ажиллагааны орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт, төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлогууд байна.

Нийт зардал өмнөх оноос 10,020,175.9 мянган төгрөг буюу 21.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, цалин хөлс, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол, нэг удаагийн тэтгэмжийн зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсөвт ТУЗ-ийн хурлаар 3 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 50,397,840.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 50,397,840.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 43,617,150.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 5,409,312.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 1,371,377.5 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 37,981,864.1 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлого 5,238,412.8 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлого 1,473,675.7 мянган төгрөгийн, нийт 44,693,952.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын гүйцэтгэл 88.7 хувьтай, урсгал үйл ажиллагаанд 43,538,435.5 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 1,141,055.6 мянган төгрөг зарцуулж 14,461.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 44,679,491.1 мянган төгрөг буюу 88.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 25,648.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 20,968.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,249.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 21,404.5 мянган төгрөг, нормативт зардал 5,542,812.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 89,290.4 мянган төгрөг, томилолт зочны зардал 1,603.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 12,268.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,060.6 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 43.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Коронавируст халдвар/Ковид-19/ цар тахлын үеийн тусламж үйлчилгээний хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас 4,881,455.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 3,279,339.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Коронавируст халдвар /Ковид-19/-тай холбоотой Эрүүл мэндийн яам, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандив, тусламж дараах байдалтай байна. Үүнд:

Харилцагчийн нэр	Мөнгөн хөрөнгө	Тоног төхөөрөмж	Багаж, хэрэгсэл	/мянган төгрөг/	
				Эм, эмнэлгийн хэрэгсэл	Бүгд
Эрүүл мэндийн яам	1,087,700.0	5,930,657.7	199,040.5	1,198,420.2	8,415,818.4
ХӨСҮТ	-	-	-	88,778.6	88,778.6
Аж ахуйн нэгж байгууллага	-	9,400.0	49,579.4	98,384.6	157,364.0
Хувь хүн	-	-	-	6,000.0	6,000.0
Нийт	1,087,700.0	5,940,057.7	248,619.9	1,391,583.4	8,667,961.0

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт нь дараах шалтгааны улмаас бүрэн хийгдээгүй. Үүнд:

- Коронавируст халдвар/Ковид-19/-ын цар тахалтай холбоотой Монгол Улсын хэмжээнд 3 удаа хатуу хөл хорионы дэглэм тогтоосноор эмнэлгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл өмнөх оноос буурсан бөгөөд хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэл өмнөх оноос 2,257 өвчтөнөөр буурсан буюу 10.9 хувь, мэс заслын тусламж үйлчилгээ 521 өвчтөнөөр буюу 7.9 хувиар тус тус буурсан;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 2021 оны эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн тайланг 12 дугаар сарын 10-наар тасалбар болгосноос 12 дугаар сарын 11-нээс 12 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацааны Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний гүйцэтгэл хянагдаагүй;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хянасан тусламж, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт оны эцэст бүрэн хийгдээгүй;

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	1	Нийт зардал	50,397,840.5	44,679,491.1	5,718,349.4	88.7
1.1	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	15,562,649.8	15,537,001.2	25,648.6	99.8
1.2	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,067,506.4	2,046,537.8	20,968.6	99.9
1.3	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,041,604.4	1,038,355.2	3,249.1	99.7
1.4	2104	Хангамж, бараа материалын зардал	296,199.2	274,794.7	21,404.5	92.8
1.5	2105	Нормативт зардал	28,171,606.1	22,628,793.6	5,542,812.5	80.3
1.6	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,726,070.1	1,636,779.7	89,290.4	94.8
1.7	2107	Томилолт, зочны зардал	24,768.6	23,165.5	1,603.1	93.5
1.8	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	122,513.9	110,245.0	12,268.9	90.0
1.9	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	243,823.5	242,762.9	1,060.6	100.0
1.10	2132	Бусад урсгал шилжүүлэг	1,141,098.6	1,141,055.6	43.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эмнэлэг нь бие даасан байдалд шилжсэнээр өндөр ур чадвартай эмч, мэргэжилтнүүдийг сүүлийн үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр ханган, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлж байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулахын тулд 2021 онд зүрх судасны тусламж үйлчилгээний чиглэлээр 3 кабинет байсныг 8 кабинет болгож нэмэгдүүлсэн нь үзлэг оношилгооны хүлээлгийн хугацааг 7-10 хоног байсныг 5-7 хоног болгож бууруулсан байна.

Коронавируст халдвар/Ковид-19/ цар тахлын үеийн тусламж үйлчилгээний хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/257, (“Коронавируст халдвар /Ковид-19/-тай иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэл батлах тухай”), мөн сайдын 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/40 (“Коронавируст халдварын оношлогоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай”) дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс Коронавируст халдвартай иргэдийг хэвтэн эмчлэх 120 орыг дэлгэн ажиллуулж байна.

Эмнэлэг нь 2021 онд эмчилгээ, оношилгооны 9 чиглэлийн нийт 27 шинэ технологи, инновацийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлж, Монгол улсаас гарах 18 гаруй тэрбум төгрөгийн мөнгөн урсгалыг зогсоож, өөрийн эх орондоо өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэд авах боломжийг бүрдүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллага нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэнтэй холбоотой байгууллагын захирлын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/274 дүгээр тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т өөрчлөлт оруулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 03 дугаар “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт”, “Эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам” зэргийг баталж, 2021 оны 03 дугаар сараас эхлэн мөрдөж эхэлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг” 2021 онд нийт 926,498,045.0 мянган төгрөгийн 170 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 41,585.6 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгууллагын тайлант оны худалдан авах ажиллагаа болон гэрээний хэрэгжилтэд дараах зөрчил байна. Үүнд:

- Байгууллага нь бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын ихэнх гэрээг он дамжуулан хийснээр гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, акт үйлдэж баталгаажуулах боломжгүй;
- Бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулахдаа гэрээний тусгай нөхцөлийг тодорхой тусгаж ажиллахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын гэрээг он дамжуулан хийхгүй байх, гэрээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дах заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж, тухай бүр хянаж ажиллах талаар албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, ТБОНӨХБАУХАТХ-тай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 25,861,114.0 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлснээс 25,635,454.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 225,660.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад хэрэгжилт 80 хувьтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 84,789.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн актын биелэлтийн хянах хугацаа хойшлогдсон, 48,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагын биелэлт 100 хувь, 352,698.3 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	84,789.3	2	84,789.3	2	84,789.3	100
Албан шаардлага	1	48,000.0	1	48,000.0	1	48,000.0	100
Зөвлөмж	6	352,698.3	6	352,698.3	6	352,698.3	100
Нийт дүн	9	485,487.6	9	485,487.6	9	485,487.6	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус эмнэлэг нь тархи, зүрхний судсан дотуурх оношилгоо, эмчилгээ, тархи, зүрхний мэс заслын лавлагаа тусламж үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлдэг мэргэжлийн төв эмнэлэг учир лабораторийн урвалж, оношлуур, цусны зохиомол эргэлтийн аппарат, зүрхний хэм алдагдлын судсан дотуурх аблаци эмчилгээний хэрэгсэл, тархины судсан дотуурх оношилгоо, эмчилгээний хэрэгсэл болох стент, койл зэрэг эм, эмнэлэгийн хэрэгслийн худалдан авалтын тендерт эдгээр эм, эмнэлгийн хэрэгслийг импортоор оруулж ирдэг 1-ээс 2 нийлүүлэгч оролцдог, өртөг үнийг харьцуулах боломжгүй, нийлүүлэгчийн үнээр худалдан авалтыг хийдэг асуудлыг анхаарч, эм, эмнэлгийн худалдан авалтыг хэрхэх талаар арга хэмжээ авах шаардлагатай байна;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоолын өөрчлөлт бодит байдалтай нийцсэн эсэх;
- Резидент эмч нарын сургалтын төлбөрийн орлогын хүлээн зөвшөөрөлт;
- Гадны болон дотоодын хандивлагчдаас үнэ төлбөргүй хандивласан хөрөнгө, материалын өртөг нь бодит үнээс хэт өндөр эсэх;
- ЭМДЕГ-ын E-Health цахим систем болон health.gov.mn цахим системийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг сайжруулж, техникийн үйл ажиллагаа хэвийн болсон эсэх;
- Урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн 10,000.0 мянган төгрөгийн зарцуулалтыг авч үзэх болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 527,787.7 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 30,261.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

4.1 Аудитын зөвлөмж

1. Цахим системтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эмнэлгийн E-health цахим системээс мэдээлэл солилцох, ашиглахад ажлын ачаалал ихтэй үеэр сервер удаашрах, гацах зэргээс шалтгаалж, асуудлууд үүсэж байна. Эмнэлгийн зүгээс цахим систем, сервер, сүлжээнд тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэж, сайжруулсаар байгаа ч тасралтгүй, хэвийн ажиллахгүй байна.

Энэ нь ажлын ачааллыг ихэсгэж, алдаа гаргах эрсдэлийг нэмэгдүүлж, ЭМДҮЗ-ийн 2020 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 4.3 заалтад байгаа “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим системд холбогдож, цахимаар хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэн, технологийн бэлэн байдлыг хангасан байна” гэснийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цахим системийн технологийн бэлэн байдлыг хангаж, техникийн тасралтгүй хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдал зэрэг нөхцлийг шийдвэрлэж, ЭМДҮЗ-ийн 2020 оны 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 19 ширхэг 15,261.5 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах.

3. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

НБББББ-ийг эргэлтийн бус хөрөнгө хэсгийн "Биет бус хөрөнгө"-ийн ангилалд 15,000.0 мянган төгрөгөөр бүртгэж, хорогдуулга тооцсон байна.

Энэ нь УСНББОУС-31-ийн 106-р зүйлд байгаа “тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулахгүй” гэснийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НБББББ-ийн ашиглах хугацааг тодорхойлж, хорогдол тооцох, эсвэл эдийн засгийн өгөөжгүй болох хүртэл хорогдол тооцохгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Улсын гуравдугаар төв эмнэлэг	АХГ-2022/369/НА-СТА-ТШЗ	УГТЭ-ийн E-health болон ЭМДЕГ-ын health.gov.mn программын уялдаа муу байна.Тухайлбал, ЭМДЕГ-ын программ серверийн ачааллаас шалтгаалж УГТЭ-ийн тусламж үйлчилгээний мэдээлэл нь зөвхөн эмнэлэгийн программд бүртгэгдэж, ачаалал хэвийн болсон үед мэдээллийг ЭМДЕГ-ын программд дахин хянаж илгээж байгаа нь ажлын ачаалал ихсэж, алдаа гаргах эрсдэлийг нэмэгдүүлж байна.	Цахим системийн технологийн бэлэн байдлыг хангаж, техникийн тасралтгүй хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдал зэрэг нөхцлийг шийдвэрлэж, ЭМДҮЗ-ийн 2020 оны 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.	1	0.0									1	0.0
2	Улсын гуравдугаар төв эмнэлэг	АХГ-2022/369/НА-СТА-ТШЗ	Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 19 ширхэг 15,261.5 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь УСНББОУС-17-ийн хүлээн зөвшөөрөлтийн шаардлагыг хангахгүй байна.	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлаж, данснаас хасах.	1	15,261.5									1	15,261.5

3	Улсын гуравдугаар төв эмнэлэг	АХГ-2022/369/НА-СТА-ТШЗ	НБББББ-т эргэлтийн бус хөрөнгө хэсгийн "Биет бус хөрөнгө" ангилалд бүртгэж, ашиглах хугацааг жилээр тогтоож, хорогдуулга тооцсон байна. Энэ нь УСНББОУС-31-ийн шаардлагыг хангахгүй байна.	НБББББ-ийн ашиглах хугацааг тодорхойлж, хорогдол тооцох, эсвэл эдийн засгийн өгөөжгүй болох хүртэл хорогдол тооцохгүй байх.	1	15,000.0									1	15,000.0
Дүн					3	30,261.5									3	30,261.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Улсын гуравдугаар төв эмнэлэг	АХГ-2022/369/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны нэгдсэн системд 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчиж байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.	1	41,585.6									1	41,585.6
2	Улсын гуравдугаар төв эмнэлэг	АХГ-2022/369/НА-СТА-ТШЗ	Гэрээний тусгай нөхцөлд гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, акт үйлдэж баталгаажуулна гэж заасан ч гэрээ дүгнэсэн нь шаардлага хангахгүй байна. Завсрын аудитаар энэ талаар зөвлөмж өгсөн хэдий ч хэтэрхий хураангуй нэр төдий тендерийн багц тус бүрээр биш нийт багцаар нь дүгнэсэн, хэтрэлттэй худалдан авалтын тооцоог хавсраагүй байна. Энэ нь гэрээний тусгай нөхцөл болон ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дах заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудад нийцэхгүй байна.	Бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын гэрээг он дамжуулан хийхгүй байх, гэрээг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дах заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж, тухай бүр хянаж ажиллах.	1	455,940.6					1	455,940.6			1	455,940.6
Дүн					2	497,526.2					1	455,940.6			1	41,585.6
Нийт дүн					5	527,787.7					1	455,940.6			4	71,847.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 250/

Улаанбаатар хот

АХГ-2022/369/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Эм, эмнэлгийн хэрэгслээс бусад бараа, ажил үйлчилгээ худалдан авах нийт 398,807,176.00 төгрөгийн гэрээг он дамжуулан хийсэн, мөн 57,133,490.00 төгрөгийн худалдан авалтын гэрээг хагас, бүтэн жилээр дүгнээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5 дугаар зүйлийн 5.1.5 "Хариуцлагатай байх, 6 дугаар зүйлийн 6.3.2 "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 "Гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний тусгай нөхцөлийг хангаж ажиллах, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хангаж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очир, Санхүү, бүртгэлийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Энхчимэгт нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЭ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА

Г.ГАНТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225_Auditm_2_Gazar-255.Docx

0010800794